


МОНГОЛЫН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГАА: ТОЙМ



▼ ИТГЭЛЦЭЛ

▼ ХАМТЫН АЖИЛЛАГАА

▼ АМЬДРАЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

▼ СЭТГЭЛ ХӨДЛӨЛ

▼ АМЬДРАЛЫН УТГА УЧИР

▼ АМЬДРАЛЫН ОЛОН ТАЛТ ҮНӨЛГЭЭ

Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) нь Монгол Улсад мэргэжлийн, хараат бус судалгааг институцийн түвшинд, тогтвортой хэрэгжүүлж буй анхны байгууллагуудын нэг юм. Бидний эрхэм зорилго бол дэлхийн жишигт нийцсэн, хараат бус судалгаа хүргэдэг, Монголын хөгжлийн салбарт тулгуурласан мэдлэгийн төв болох явдал юм. Бид олон нийтэд хараат бус, чанартай мэдээллийг түгээж, сайн сайхан нийгмийг цогцлоох, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хоорондын хамтын ажиллагааг дэмжих, Монголын хүн амын хэрэгцээнд нийцсэн шинэлэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорьж байна. IRIM нь “Азийн Нийгмийн сайн сайхан байдлын консорциум” болон “Олон улсын Социологийн холбоо”-ны гишүүн юм.

Бидэнтэй холбогдох:

Цахим шуудан: contact@irim.mn

Цахим хуудас: www.irim.mn

Фэйсбүүк /Твиттер хуудас: [@IRIMongolia](https://www.facebook.com/IRIMongolia)

Тайланг эш татах:

IRIM (2018), “Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”
Улаанбаатар. IRIM судалгааны хүрээлэн

Зохиогчид

Алдарын Долгион, Цэвэгдоржийн Болд, Лхагваноровын Дашзэвэг,
Ядмаагийн Бямбасүрэн, Цэдэндамбын Батсугар

Мэдэгдэл

Энэхүү тайлангийн агуулга нь судалгааны багийн үзэл бодол ба IRIM судалгааны хүрээлэнгийн албан ёсны байр суурийг төлөөлөхгүй болно.

Зохиогчийн эрхийн талаар мэдээлэл

Энэхүү тайланг түгээх, дамжуулах, татаж авах болон хэвлэх боломжтой бөгөөд IRIM судалгааны хүрээлэнгийн эх сурвалж ба зохиогчийн эрхийг зохих ёсоор дурьдаж тайлангийн хэсгээс эшлэл татаж болно.

АГУУЛГА

ХУРААНГУЙ	2
ИТГЭЛЦЭЛ	4
ХАМТЫН АЖИЛЛАГАА	7
АМЬДРАЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖ	10
АМЬДРАЛЫН ОЛОН ТАЛТ ҮНЭЛГЭЭ	14
СЭТГЭЛ ХӨДЛӨЛ	15
АМЬДРАЛЫН УТГА УЧРЫН ТАЛААРХ АСУУЛТУУД	17
УЛС ХООРОНДЫН ХАРЬЦУУЛАЛТ	19
ТАЙЛАНГИЙН ТУХАЙ	20
СУДАЛГААНЫ ТУХАЙ	22

ХУРААНГУЙ

Энэхүү тайланд IRIM судалгааны хүрээлэнгийн 2016-2018 онд хэрэгжүүлсэн “Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-ны товч үр дүнг танилцуулсан болно. Тайлангийн онцлох үр дүнгүүд:

- Нийгмийн итгэлцэл ба бусадтай хамтарч ажиллах үзүүлэлтүүд доогуур гарав. Судалгаанд оролцогчдын талаас илүү нь (61%) бусдад итгэхгүй гэж хариулжээ. Мөн бусдад туслах, бусдаас тусламж авах талаарх төсөөлөл мөн доогуур байна (10 онооноос 4.7 оноо).
- Монгол дахь хүмүүс хоорондын итгэлцэл, хамтын ажиллагаа нь гэр бүл, хамаатан садан зэрэг хувийн харилцаанд суурилсан байна. Хүмүүс өөрсдийн гэр бүл, найз нөхөд, хамаатан саданд туслахад бэлэн байсан бол ЛГБТ бүлэг, танихгүй хүн, өөр шашинтай болон өөр үндэстний хүмүүст туслахыг хүсэх нь хамгийн бага байв. Энэ нь Монголчууд өөрсөдтэйгөө төстэй шинж чанартай бүлгүүдэд итгэх, тэдэнтэй хамтарч ажиллах сонирхол өндөртэй болохыг харуулж байна.
- Монголчууд өөрсдийн хувийн амьдралдаа сэтгэл ханамжтай байна (дунджаар 10 онооноос 7.5 оноо авсан бөгөөд энэ нь бусад оронтой харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт юм). Судалгаанд оролцогсад өөрсдийгөө харьцангуй аз жаргалтай, амьдралын утга учиртай байдаг гэж хариулжээ.
- Хүмүүсийн ирээдүйн амьдралын талаарх төсөөлөл зэрэг, өнгөрсөн амьдралын талаарх төсөөлөл сөрөг, одоогийн талаарх төсөөлөл дундаж байв.
- Монголчууд өөрсдийн хувийн орон зай, харилцаа болон амьдралыг үнэлэх үнэлгээ ба гадаад орчин буюу нийгэм, эдийн засаг, байгаль орчин, улс төрийг үнэлэх үнэлгээний хооронд маш том зөрүү байна. Өөрөөр хэлбэл тэд өөрсдийн хувийн харилцаа зэрэгт сэтгэл ханамжтай, өөрсдийн боловсролын түвшин, аюулгүй байдал зэрэгт бага зэрэг сэтгэл зовнисон харин Монголын эдийн засаг, улс төрийн талаар огт сэтгэл ханамжгүй байна.

Тэгш бус байдал

- Амьдралын сэтгэл ханамжид орлогын ялгаатай байдал хамгийн өндөр нөлөөтэй байв. Өндөр орлоготой хүмүүс илүү сэтгэл ханамжтай, бага орлоготой хүмүүсийн амьдралын сэтгэл ханамж харьцангуй доогуур байна.

- Мөн нас, хүйс, боловсрол, газар зүйн байршил зэрэг нь амьдралын сэтгэл ханамжид нөлөөлж байна.
- Итгэлцэл, хамтын ажиллагааны хувьд судалгаанд хамрагдагчдын нас ба ажил эрхлэлтийн байдал нөлөөтэй байв.
- Нийгмийн бүлэг доторх ба бүлгүүд хооронд субъектив сайн сайхан байдлын тэгш бус байдал байгаа эсэхийг тодруулах нь хөгжлийг хэмжих чухал индикатор болдог.

Бодлогын асуудлууд


- Нийгмийн ерөнхий итгэлцлийг дээшлүүлэх, хүмүүс хоорондын хамтран ажиллах хүсэл ба туршлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга замыг тодорхойлох шаардлагатай байна. Ийнхүү нийгмийн нийцлийг нэмэгдүүлэх нь эдийн засгийн үзүүлэлт, сайн сайхан байдал, ардчиллыг бэхжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зэрэг урт хугацааны чухал бодлогуудад хөрөнгө оруулалт хийхийг олон нийт дэмжих зэрэг ач холбогдолтой.
- Ядуу ба эмзэг бүлгүүдэд чиглэсэн бодлого нь ядуурлыг бууруулахад чиглэсэн хэвээр байхын зэрэгцээ боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлт зэрэг нийгмийн үйлчилгээг сайжруулахад анхаарах хэрэгтэй байна. Нийгмийн зорилтот бүлэгт нэн тэргүүнд найдвартай орлогын эх үүсвэр хэрэгцээтэй байна.
- Нийгэм дэх үнэт зүйлс, үнэлэмж нь хүмүүсийн нас, орлого, оршин суугаа газар зэргээс хамааран ялгаатай байгаа нь ажиглагдаж байна. Тиймээс цаашид Монгол дахь нийгмийн үнэлэмжийг судлах гүнзгийрүүлсэн судалгааг тогтмол хийх хэрэгтэй байна.
- Тиймээс бид энэхүү судалгаагаа цаашид үргэлжлүүлэн, тогтмол хэрэгжүүлэх улмаар олон жилийн харьцуулсан мэдээлэл цуглуулах зорилго тавин ажиллаж байна. Судалгааны үр дүнг орон нутгийн түвшинд, тодорхой бүлгүүдийн түвшинд мөн тодорхой бодлого, хөтөлбөр, төслүүдийн үр дүнг үнэлэхэд ашиглах боломжтой. Бид судалгааны үр дүнгээ хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран тогтмол олон нийтэд түгээх болно.

ИТГЭЛЦЭЛ


Иргэд хоорондоо хамтран ажиллахад тэдний хооронд итгэлцэл байгаа эсэх нь чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайн нийгмийн гишүүдийн дунд итгэлцэл бага байх тусам нийгэм дэх бүхий л үйл ажиллагааг удаашруулж, хамтын ажиллагааг бууруулж иргэдэд дарамт үүсгэдэг (Fukuyama 1995).

Ерөнхийд нь хэлбэл ихэнх хүмүүст итгэж болно гэж боддог уу эсвэл хүмүүстэй харилцахдаа маш болгоомжтой байх шаардлагатай гэж бодож байна уу?

Дүрс 1 Дундаж утга




Дүрс 2 Судалгаанд оролцогчдын хариултын тархалт (%)




Таны бодлоор ихэнх хүмүүс боломж гарвал таныг ашиглахыг оролддог уу эсвэл шударга байхыг оролддог уу?

Дүрс 3 Дундаж утга



Дүрс 4 Судалгаанд оролцогчдын хариултын тархалт (%)



Дээрх асуултуудын хариултууд дунджаас доогуур байгаа нь Монголчуудын хоорондын “ерөнхий” харилцан итгэлцэл тийм ч өндөр биш байгааг харуулж байна. Судалгаанаас харахад хүйс, хот хөдөөгийн ялгаа, орлогын түвшин зэргээс хамаарсан ялгаатай хариултууд ажиглагдаж байсан ч энэ нь статистикийн хувьд ач холбогдолгүй байна.


Дүрс 5 Судалгаанд оролцогчдын хариултын дундаж утга, бүлэг тус бүрээр

	Ерөнхийд нь хэлбэл ихэнх хүмүүст итгэж болно гэж боддог уу?	Таны бодлоор ихэнх хүмүүс боломж гарвал таныг ашиглахыг оролддог уу эсвэл шударга байхыг оролддог уу?
Эрэгтэй	4.77	4.89
Эмэгтэй	4.59	5.08
Хот	4.60	4.59
Хөдөө	4.71	5.22
Өндөр орлоготой	5.22	5.28
Бага орлоготой	4.78	5.44
Өндөр боловсролтой	4.68	5.04
Бага боловсролтой	4.21	4.81
Ажил эрхэлдэг	4.72	4.99
Ажил эрхэлдэггүй	4.60	4.99
Гэр бүлтэй	4.71	4.80
Гэр бүлгүй	4.62	5.25

Independent Research Institute of Mongolia

Итгэлцлийн талаар нарийвчлан тайлбар өгөхийн тулд бид судалгаандаа нийгмийн ерөнхий итгэлцэл болон нийгмийн тухайлсан итгэлцлийн аль алиных нь статусыг, мөн итгэлцлийн чухам ямар мэдрэмж ба харилцан ойлголцол дээр Монголын нийгэм тулгуурладаг болохыг тодорхойлохыг оролдсон.

Дүрс 6 Нийгмийн аль бүлэгт хамгийн их итгэдэг вэ? (%)




Судалгаанд оролцогчид танихгүй хүмүүст (3.06) хамгийн бага, харин өөрийн гэр бүлийнхэнд (9.74) хамгийн их итгэдэг ажээ. Монголд хувь хүмүүсийн хоорондын итгэлцэл бусад нийгмийн бүлгүүдэд итгэхээсээ илүүтэй гэр бүлийн харилцаанд төвлөрсөн шинжтэй байна. Олон улсын түвшинд харьцуулбал (Дэлхийн үнэлэмжийн судалгааны үр дүнгийн (2010) талаарх Ларсений дүн шинжилгээнд (2014)) 52 орны 5-д нь “бусдад итгэдэг” гэсэн хариулт “бусдад итгэдэггүй” гэснээсээ өндөр байдаг. Ларсен (2014) “нийгмийн итгэлцэл өндөр түвшинд байх нь ховор үзэгдэл юм” хэмээн онцолсон байна. Үүнтэй адилаар Монголд ч мөн хүн амын талаас илүү хувь нь (61% нь 5 хүртэлх оноогоор үнэлсэн) “бусдад итгэдэггүй” гэж хариулсан байлаа.

ХАМТЫН АЖИЛЛАГАА


Нийгмийн нийцэл (social cohesion) нь хувь хүмүүс хоорондын итгэлцэл, хамтын үр дүнд хүрэхийн төлөө бие биетэйгээ хамтран ажиллах хүсэл зорилготой байх эсэхээс хамаардаг (Stanley 2003, 8).

Ерөнхийд нь хэлбэл хүмүүс ихэнхдээ бие биедээ тусархаг байдаг уу эсвэл өөрсдийгөө дор дороо болгоод явдаг уу?

Дүрс 7 Дундаж утга



Дүрс 8 Судалгаанд оролцогчдын хариултын тархалт (%)



0=Хүмүүс ихэнхдээ бие биедээ тусархаг байдаг 10=Хүмүүс ихэнхдээ өөрсдийгөө дор дороо болгодог

Ерөнхийдөө тусархаг байдлын дундаж оноо дунджаас доогуур (4.7) үзүүлэлттэй гарсан. Судалгаанд оролцогчдын нийгмийн зарим бүлэгт туслах эрмэлзлийг авч үзвэл гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хамаатан садандаа туслах эрмэлзэл бусад бүлэгтэй харьцуулахад өндөр байв. Харин судалгаанд оролцогчид ЛГБТ хүмүүс, танихгүй хүмүүс, шашны итгэл үнэмшил өөр болон өөр үндэстний хүмүүст туслах эрмэлзэл нь хамгийн бага байлаа. Тодруулбал Монголчууд хувийн харилцаатай хүмүүстээ туслахыг илүүд үзжээ.

Хүмүүст туслах эрмэлзэл болон бусдаас туслалцаа авах хүлээлт

Дүрс 9 Тийм гэсэн хариулт өгсөн судалгаанд оролцогчид (%)

	Нийгмийн бүлгүүд	Ерөнхийд нь хэлбэл ихэнх хүмүүст итгэж болно гэж боддог уу?	Таны бодлоор ихэнх хүмүүс боломж гарвал таныг ашиглахыг оролддог уу эсвэл шударга байхыг оролддог уу?
1	Таны гэр бүл	98.3	97.5
2	Найз нөхөд	94.0	90.3
3	Хамаатан, төрөл садан	93.0	88.3
4	Хамтран ажиллагсад	90.3	84.1
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	78.7	50.9
6	Хөршүүд	72.9	64.0
7	Өөр нутаг, усныхан	65.7	48.3
8	Өөр үндэстэн	54.2	37.4
9	Өөр шашинтай хүмүүс	49.5	36.9
10	Анх удаа уулзаж байгаа хүн / Танихгүй хүн	46.7	28.2
11	ЛГБТ хүмүүс	34.2	25.9


Харилцан бие биедээ туслах байдлын хувьд хүмүүс бусдын тусламжаас илүүтэй өөрсдийн туслалцааг илүү үнэлсэн байлаа. Бусдад туслах болон тусламж хүлээх байдал танихгүй хүмүүс, өөр шашинтай хүмүүс, өөр үндэс угсаатан, өөр аймгийн хүмүүсийн хувьд харьцангуй бага байв. Харилцаа холбоо нь ойртох тусам харилцан туслалцах байдал нь ихэсч буй зүй тогтол ажиглагдсан. Гэр бүл, найз нөхөд, хамаатан садан болон хамтран ажиллагсдын харилцан туслалцах байдлын ялгаа бүгд 10-аас доош хувьтай байв. Судалгаанд оролцогчдын зөвхөн 28% нь л танихгүй хүн өөрсдөд нь тусална гэдэгт итгэдэг байна.

Бид судалгаанд оролцогчдын хамтын ажиллагаатай холбоотой тодорхой үйлдэл болон туршлагынх нь талаар судалсан. Ямар нэгэн байгууллагын гишүүнчлэлтэй хүмүүс бага хувьтай байсан бөгөөд хүмүүс нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдоггүй болохыг энэхүү үр дүн харуулсан. Хүмүүс бусдад зохион байгуулалттайгаар хамтран туслахаас илүүтэй хувь хувиараа (оролцогчдын бараг тал хувь нь танихгүй хүмүүст тусалж мөнгө хандивласан байна) туслах явдал өндөр хувьтай байна.

Дүрс 10 Байгууллагуудад гишүүнчлэлтэй эсэх ("тийм" гэсэн хариултын %)



Дүрс 11 Та өнгөрсөн нэг сарын хугацаанд дараах зүйлсийг хийсэн үү? ("тийм" гэсэн хариултын %)




АМЬДРАЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖ


Амьдралын сэтгэл ханамж гэдэг нь хүмүүс өөрсдийн амьдралаа хэрхэн үнэлж буй хэмжүүр юм. Энэ нь хүний тухайн үеийн сэтгэл хөдлөлийн гэхээс илүүтэй когнитив үнэлгээ юм. Уг үзүүлэлтийг тодорхойлохдоо “Кантрилийн шатлал” буюу оролцогчдыг 0-ээс 10 хүртэлх гишгүүртэй шат төсөөлж өөрийн амьдралыг аль шатанд байгааг үнэлэхийг хүсдэг. Шатны хамгийн дээд гишгүүр буюу 10 оноо нь байж болох хамгийн сайхан амьдралыг, харин хамгийн доод гишгүүр буюу 0 нь амьдралын байж болох хамгийн муу түвшинг илэрхийлнэ (OECD 2013, 268).

Ерөнхийдөө, та өнөөдрийг хүртэлх амьдралдаа хэр зэрэг сэтгэл ханамжтай байна вэ?

Дүрс 12 Дундаж утга




Дүрс 13 Судалгаанд оролцогчдын хариултын тархалт (%)




Та амьдралынхаа туршид хийж байгаа зүйлсээсээ хэр зэрэг үр дүнг мэдэрдэг вэ?

Дүрс 14 Дундаж утга



Дүрс 15 Судалгаанд оролцогчдын хариултын тархалт (%)




Монголчууд өөрсдийн амьдралд сэтгэл хангалуун байгаа нь ажиглагдсан. Энэ нь бусад орнуудтай харьцуулбал харьцангуй өндөр үзүүлэлт юм. Тухайлбал Скандинавын орнууддахь амьдралын сэтгэл ханамжийн үзүүлэлт дунджаар 7.5 байдаг бол Сиричүүд, Бурундичууд болон Төв Африкийн орнуудад амьдралын сэтгэл ханамжийн үзүүлэлт хамгийн бага буюу 3.0 байв (Gallup-ын Дэлхий нийтийн Судалгаа 2017). Мөн судалгаан оролцогсад өөрсдийнхөө амьдралыг утга учиртай мөн өөрсдөө харьцангуй аз жаргалтай байдаг гэж дүгнэжээ. Энэ нь Монголчуудын сэтгэлгээ болон илүү “харилцааны шинжтэй сайн сайхан байдал” өндөр байдагтай нь холбоотой байж болох юм.


Илүү орлоготой хүмүүс амьдралдаа илүү сэтгэл ханамжтай байсан бөгөөд орлогын түвшин нь амьдралын сэтгэл ханамжийг өндөр түвшинд байлгахад хамгийн их нөлөөлж байна. Түүнчлэн нас, хүйс, боловсролын түвшин болон суурьшлын төрөл зэрэг нь амьдралын сэтгэл ханамжийн ялгаатай байдалтай уялдаатай байлаа.

Бүх зүйлсийг хамруулан авч үзвэл та өөрийгөө хэр зэрэг аз жаргалтай гэж хэлэх вэ?

Дүрс 16 Дундаж утга




Дүрс 17 Судалгаанд оролцогчдын хариултын тархалт (%)




Амьдралыг 10 гишгүүртэй шат гэж үзвэл та өөрийгөө аль гишгүүр дээр нь байгаа гэж үзэх вэ?

Дүрс 18 Дундаж утга


5 жилийн өмнө:



Өнөөдрийн байдлаар:




5 жилийн дараа:



АМЬДРАЛЫН ОЛОН ТАЛТ ҮНЭЛГЭЭ

Амьдралын олон талт байдлын сэтгэл ханамжийн талаарх асуултуудыг зөвхөн өөр хооронд нь дунджилж шинжлэхээс гадна тус бүрт нь бие даан шинжлэх боломжтой. Өөрөөр хэлбэл эдгээр асуулт нь холбогдох бодлого, арга хэмжээний үр нөлөөг судлах, үнэлэхэд ач холбогдолтой байдаг (ЭЗХАХБ 2013).

Дүрс 19 Та дараах зүйлсдээ хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?



Хүмүүс гадаад орчин болон хувийн орчиндоо хэрхэн үнэлэлт өгч байгаа нь ялгаатай байв. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь гадаад орчин болох улс төрийн нөхцөл байдал, эдийн засгийн нөхцөл байдал, Монгол улсын байгаль орчин зэрэгт сэтгэл ханамжгүй байсан. Хүмүүс өөрсдийн боловсролын түвшин, ирээдүйн амьдралын баталгаат байдал, ажил мэргэжил болон аюулгүй байдалдаа илүү санаа зовниж байсан.

Бусад бүх олон талт байдлын талаарх асуултын хувьд бүрэн сэтгэл ханамжтай хүмүүс дийлэнх нь байлаа. Хүмүүс гэр бүл, амьдралаас олж авсан зүйлс, хувийн харилцаа болон өөрийн сонирхолтой зүйлсдээ зарцуулдаг цагтаа хамгийн их сэтгэл ханамжтай байв.

Судалгаанд оролцогчдоос өөрийн амьдралын олон талыг үнэлэх нийт 19 асуулт асуусан. Үүнээс дөрвөн төрлийн (орчин, аюулгүй байдал, чөлөөт цаг болон амьдралын түвшин) үнэлгээнд орлогын бүлгээс хамаарсан ялгаа байгаагүй. Харин бусад 14 төрлийн үнэлгээнд ялгаа гарсан ба бага орлоготой хүмүүс амьдралдаа харьцангуй доогуур сэтгэл ханамжтай байгаа нь илэрсэн. Харин Монголын улс төрийн нөхцөл байдалд бага орлоготой хүмүүс бусад орлогын бүлэгтэй харьцуулахад бага зэрэг сэтгэл ханамжтай гэсэн үзүүлэлттэй гарсан байлаа.


СЭТГЭЛ ХӨДЛӨЛ

Эдгээр асуултуудаар судалгаанд оролцогчдын сүүлийн үед мэдэрсэн эерэг болон сөрөг сэтгэл хөдлөлийн төлөв байдлыг тодруулахыг зорьдог. Эерэг болон сөрөг сэтгэл хөдлөлийн талаарх асуултууд нь субъектив сайн сайхан байдлыг тодорхойлох гол элемент болдог (когнитив үнэлгээний шинжтэй асуултуудаас гадна) (OECD 2013, 257). Доорх хүснэгтэд судалгаанд оролцогчдын хариулснаар сэтгэл хөдлөлийн төлөв байдлын дундаж утгыг харуулав.

Дүрс 20 Та өчигдөр дараах сэтгэл хөдлөлүүдийг хэр зэр мэдэрсэн бэ? (Дундаж утга)

	Асуулт	Дундаж утга
эерэг	Та өчигдөр хэр баяр баясгалантай байсан бэ?	7.63
	Та өчигдөр хэр зэрэг тайван амгалан байсан бэ?	7.59
	Та өчигдөр хэр зэрэг аз жаргалтай байсан бэ?	7.42
	Өчигдөр таны эрүүл мэндийн байдал хэр зэрэг байсан бэ?	5.73
	Та өчигдөр маш их инээж бусдыг шоолсон уу?	4.04
сөрөг	Та өчигдөр хэр зэрэг ядарсан бэ?	4.31
	Та өчигдөр хэр зэрэг санаа зовсон бэ?	3.18
	Та өчигдөр хэр зэрэг уйтгар гунигтай байсан бэ?	2.50
	Та өчигдөр хэр зэрэг бухимдалтай байсан бэ?	2.40
	Та өчигдөр хэр зэрэг стресс/сэтгэл санааны хямралтай байсан бэ?	2.36
	Та өчигдөр хэр зэрэг сэтгэл гутралд автсан бэ?	2.26

Дүрс 21 Та өчигдөр дараах сэтгэл хөдлөлүүдийг хэр зэр мэдэрсэн бэ? (Судалгаанд оролцогчдын хариултын тархалт %)




Хүмүүсийн сэтгэл хөдлөлийн байдалд улирлын нөлөөлөл мөн судалгаанд оролцогчийн гэрлэлтийн байдал, хот эсвэл хөдөөд амьдардаг эсэх нь нөлөөлдөг болох нь судалгаанаас илэрсэн. Тухайлбал судалгаанд ороцлогчдын нийгэм эдийн засгийн статусаас үл хамааран сэтгэл хөдлөлийн эерэг үнэлгээ намрын улиралд (6.9) хамгийн их, өвлийн улиралд (6.2) хамгийн бага байсан бол орон нутагт оршин суугчдынх (7.5) хот суурин газрынхтай (6.3) харьцуулбал илүү эерэг, гэрлэсэн хүмүүс (7.3) гэрлээгүйгээсээ (6.9) илүү эерэг үнэлгээтэй байсан.

АМЬДРАЛЫН УТГА УЧРЫН ТАЛААРХ АСУУЛТУУД


Эдгээр асуултуудаар хүмүүс сэтгэл зүйн хувьд эрүүл, эерэг, хангалуун байхад нөлөөлөх сэтгэл зүйн олон талт байдлыг хэмждэг ба эдгээр асуултыг юдаймония асуулт гэж нэрлэдэг (OECD 2013, 32). Судалгаанд оролцогчийн бие даасан байдал (өөрөө өөртөө эзэн болох), ур чадвар, амьдралын зорилго ба утга учрын талаарх асуултууд үүнд багтана. Эдгээр нь субъектив сайн сайхан байдлын талаарх судалгааны бусад асуултуудтай харьцуулахад харьцангуй шинээр хэрэглэгдэж эхэлсэн, хамгийн бага судлагдсан бүлэг асуулт юм.

Ерөнхийдөө, амьдралынхаа туршид хийж буй зүйлсдээ хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?


Дүрс 22 Дундаж утга



Дүрс 23 Судалгаанд оролцогчдын хариултын тархалт (%)



Дүрс 24 Та дараах зүйлсдээ хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?



Монголчуудын хувьд сэтгэл зүйн ерөнхий шинж хандлага харьцангуй өндөр, сэтгэл ханамжтай гэсэн үр дүн гарсныг дээрх зургаас харж болохоор байна. Тэр дундаа Монголчууд өөрсдийн “бие даасан байдал” (өөрийнхөө төлөө шийдвэр гаргах, амьдралын утга учир зорилгоо тогтоох эрх чөлөө,)-даа хамгийн сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээ өгсөн байна. Харин сүүлийн үеийн нөхцөл байдал болон ур чадварынх нь талаар асуухад сөрөг хариулт өгсөн хүмүүсийн тоо бага зэрэг өссөн.


УЛС ХООРОНДЫН ХАРЬЦУУЛАЛТ

Монгол дахь субъектив сайхан байдал нь бусад улс орнуудтай харьцуулахад хэр өндөр эсвэл бага байдаг вэ? Уг асуултад хариулахдаа бид судалгааны үр дүнгээ “Дэлхийн аз жаргалын тайлан (2017)”-гийн үр дүнтэй харьцуулав. Монгол улс нийт 141 орноос 61-т жагсаж байв. Уг тайланд дурдсанаар Монгол дахь аз жаргалтай байдлын үзүүлэлт 2007 оноос хойш аажмаар нэмэгдэж байгаа аж (4.61). Түүнчлэн аз жаргалтай байдлын үзүүлэлт нь манай хөрш орнууд болох Орос, Хятад мөн бусад Төв Азийн орнуудтай ойролцоо түвшинд байна.

Дүрс 25 Cantril Ladder

World Happiness Report 2016

Sweden	7.2868047	Switzerland	7.4735932
Austria	7.2937279	Iceland	7.4762139
New Zealand	7.3271828	Norway	7.5787449
Israel	7.3310361	Denmark	7.5937023
Netherlands	7.4589653	Finland	7.7882519



0= Огт сэтгэл ханамжгүй

10= Бүрэн дүүрэн сэтгэл ханамжтай

ТАЙЛАНГИЙН ТУХАЙ

Бид зөвхөн материаллаг баялаг бүхий нийгэм биш харин иргэд нь бие биедээ харилцан итгэдэг, хамтран ажилладаг, харьцангуй тэгш, амар тайван, аз жаргалтай, сайн сайхан нийгмийг цогцлоохыг хүсдэг. Харин ийм нийгмийг бүрдүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхийн тулд уламжлалт ДНБ зэрэг эдийн засгийн хэмжүүрээс гадна нийгмийн сайн сайхан байдлыг илэрхийлсэн хэмжүүр, үзүүлэлтийг ашиглах шаардлагатай.

Сүүлийн хорь гаруй жилийн турш нийгмийн сайн сайхан байдлын бүрдэл хэсэг болох субъектив сайн сайхан байдлыг хэмжих, үнэлэх онолын ба практик боломж нэмэгдсээр байна. Тухайлбал, Галлап олон улсын судалгаа (the Gallup World Poll), Дэлхийн үнэлэмжийн судалгаа (World Values Survey), Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Амьдралын сайн сайхан байдлын индексүүд (OECD Better Life Index) зэргийг дурдаж болно. Нийгмийн сайн сайхан байдлыг хэмжихэд ийнхүү дэлхий нийтээрээ ахиц гаргаж байгаа ч Монгол улсын хувьд энэ талаар тогтвортой бөгөөд үндэсний хэмжээнд хийгддэг судалгааны ажил хомс байна. Энэ талаар судалгаа, тодорхой мэдээлэл хомс байна гэдэг нь манай улсад иргэдийнхээ нийгмийн талаарх үнэлгээг харгалзсан төрийн бодлого, шийдвэр гаргах урьдач нөхцөл бүрдэх боломж мөн хомс байна гэсэн үг юм.

Уг тайланд нийгмийн сайн сайхан байдал гэдэг нь “аз жаргал” хэмээх ойлголтоос илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Уг ойлголтоор нийгэм ба хувь хүний субъектив үнэлгээ, мэдрэмж мөн нийгмийн гишүүд хоорондын харилцааг илэрхийлдэг. Энэ утгаараа нийгмийн сайн сайхан байдлын судалгаа нь сүүлийн үед тархах болсон “аз жаргалын бизнес”-д зориулагдаж гардаг мэдээллүүдээс илүү ул суурьтай байж чаддаг.

Бидний танилцуулж буй энэхүү “тойм” тайлан нь Монголын нөхцөлд хэд хэдэн талаараа шинэлэг юм:

- Үндэсний болон хараат бус судлаачид бие даан явуулсан
- Жилийн өөр өөр улирал, сар, өдрүүдэд явуулсан ба УИХ-ын сонгуулийн жил (2016 он), Ерөнхийлөгчийн сонгуулийн жил (2017 он)-д хийгдсэн. 2018 онд мөн үргэлжлүүлэн хийгдэж байна.
- Үндэсний хэмжээнд төлөөлөхүйц түүврээс судалгааны мэдээллийг бүрдүүлсэн
- Бусад улс орон, нийгмийн бүлгүүд, цаг хугацааны хувь харьцуулагдахуйц зэрэг болно.

Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа нь IRIM Хараат бус судалгааны хүрээлэнгийн Монголын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн мэдлэгийн төв болох эрхэм зорилгодоо хүрэх нэг алхам, илэрхийлэл болж байгаа юм. Тус судалгааг Хараат бус судалгааны хүрээлэнгээс санхүүжүүлсэн болно.

Бидэнтэй хамтарч ажиллах

Бид цаашдаа Монгол дахь нийгмийн нийцэл, субъектив сайн сайхан байдлыг үргэлжлүүлэн судлах, судалгааны мэдээллийг Англи, Монгол хэл дээр онлайнаар нийтлэх, судалгааны хамрах хүрээг тэлэх, бодлогын өөрчлөлт бий болгох нөлөөллийн ажилд нээлттэй ашиглах боломжтой болгохын төлөө ажиллаж байна.

Тиймээс та бүхэн бидний санаачилгад дараах байдлаар нэгдээрэй:

- Бидний зорьж буй ажилд санхүүгийн хувь нэмэр оруулах
- Өөрийн цагаа бидэнд зориулж сайн дурын ажил хийх
- Бидний судалгааны тайлан болон мэдээллийг ашиглах
- Бидэнтэй эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг бий болгох
- Бидэнтэй бодлогын түншлэлийг бий болгох
- Судалгааны талаар үзэл бодлоо бидэнтэй хуваалцах, санал өгөх

СУДАЛГААНЫ ТУХАЙ

Бид нийгмийн суурь судалгааг олон түүврийн хүрээнд тогтмол хугацаанд үргэлжлүүлэн явуулж олон улс орон, цаг хугацааны туршид харьцуулалт хийх боломжийг бий болгохыг зорьж байна. Эдгээр судалгаануудын үр дүнд бид дараах асуултуудад хариулт өгөхүйц нийгмийг бүхлээр нь тайлбарлах судалгаа Монголд дутмаг байгааг илэрхийлэхийг хүссэн. Үүнд:

- Хувь хүн болон нийгэм хэрхэн өөрчлөгдөж байна вэ?
- Тэдгээрийн онцлог шинж чанар
- Эдгээр нийгмийн асуудлуудад чиглэсэн ямар арга хэмжээ авах нь зүйтэй вэ?

Судалгааны хүрээ

Нийгмийн нийцэл

Нийгмийн нийцэл (social cohesion) нь хувь хүмүүсийн нэгдмэл зорилгод хүрэхийн төлөөх нийгмийн аль ч түвшинд хамтран ажиллах хүсэл эрмэлзэл, хамтын ажиллагаан дээр үндэслэдэг (Jenson 2003). Нийгмийн нийцэл гэдэгт дараах гурван түвшинг авч үздэг (Dolgion A. and Tamir Ch. 2015):

- Бие биеэс харилцан хамаарах - Нийгмийн гишүүдийг нэгтгэж байдаг “адилсал” байх, нийгэмд хамаарч буйгаа мэдэрч байх.
- Итгэлцэл - Нийгмийн гишүүд бие биедээ ба улс төрийн институцүүдэд итгэдэг байх
- Хамтын ажиллагаа - Нийгмийн гишүүдийн субъектив мэдрэмж нь тэдний объектив зан үйл, үйлдлээр илэрдэг байх – харилцан бие биедээ тусалдаг, хамтардаг байх.

Уг судалгаандаа бид эхний ээлжид нийгмийн нийцлийн итгэлцэл ба хамтын ажиллагаа гэсэн элементүүдийг хамруулсан. Итгэлцэл дундаа нийгмийн итгэлцэл буюу иргэд хоорондын итгэлцлийг судалсан. Бид судалгаандаа олон улсад харьцуулагдахуйц байх үүднээс Дэлхийн үнэт зүйлсийн судалгаа (World Values Survey), Европын нийгмийн судалгаа (European Social Survey)-нд ашиглагддаг нийгмийн итгэлцэл, хамтын ажиллагааг хэмжих асуултуудыг орчуулан ашигласан.

Субъектив сайн сайхан байдал

Субъектив сайн сайхан байдал нь дан ганц нийгэмд буй үнэлэгдэхүйц амжилт дэвшил бус түүнээс харьцангуй цогц ойлголт юм. Бид

субъектив сайн сайхан байдлыг хэмжихдээ Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (OECD) –ын боловсруулсан арга зүйн хүрээг суурь болгон ашигласан. Субъектив сайн сайхан байдлын дараах элементүүдийг уг судалгаагаар хэмжсэн:

- Амьдралын үнэлгээ– Хүний амьдрал эсвэл түүний тодорхой нэг онцлог талын когнитив үнэлгээ. Хүмүүсийг өөрийгөө амьдралын талаар эргэцүүлэн бодож ерөнхийдөө амьдрал нь хэрхэн явж байгааг үнэлүүлэх асуултууд.
- Сэтгэл хөдлөл– Хувь хүний сайн сайхан байдлыг өдөр тутмын үндсэн дээр үнэлэхийн тулд хүмүүсийн богино хугацаан дахь мэдрэмж болон сэтгэл санааны байдлын талаар асуудаг.
- Амьдралын утга, учрын үнэлгээ (eudaimonia)– Энэ нь зөвхөн аз жаргалтай байдал, эерэг сэтгэл хөдлөлөөс илүү өргөн хүрээний субъектив сайн сайхан байдлыг илэрхийлдэг. Хүмүүс амьдралын утга учир болон зорилгыг хэрхэн мэдэрч байгаа, сэтгэл зүйн хувьд хэр хангалуун байгаа асуудаг.

Тайланг энгийн байлгахын тулд субъектив сайн сайхан байдлын түвшинг нэгтгэн дүгнэж хэмжүүрүүдийг ангилахдаа дундаж утгаар илэрхийлсэн болно.

Асуулга

Судалгааны асуулга нь дараах бүтэцтэй бөгөөд уг тайланд зөвхөн тойм асуултуудын боловсруулалт, үр дүнг танилцуулсан болно.

Асуумжийн бүтэц	Асуулгын тоо
Респондент, өрхийн талаарх мэдээлэл	25
Итгэлцэл	12
Хамтын ажиллагаа	15
Амьдралын сэтгэл ханамж	12
Сэтгэл хөдлөл	11
Амьдралын олон талт байдлын үнэлгээ (domain evaluation)	19
Амьдралын утга, учрын үнэлгээ (eudaimonic evaluation)	9

Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаагаар, 15 ба түүнээс дээш насны 2318 хүнтэй таблет болон цаасан асуулга ашиглан нүүр тулсан ярилцлага хийсэн.

Independent Research Institute of Mongolia

Судалгааг 2016 оны 6-р сараас 2017 оны 11 сар хүртэлх хугацаанд 4 удаагийн давтамжтайгаар явуулсан. Судалгаанд дараах аймаг, хотуудыг хамруулсан: Баянхонгор, Дорнод, Говь-Алтай, Хэнтий, Ховд, Сэлэнгэ, Өмнөговь, Өвөрхангай, Завхан ба Дархан, Эрдэнэт, Улаанбаатар хотууд.

Хэмжилт ба дүн шинжилгээ

Субъектив сайн сайхан байдал нь Cantril Ladder (өөрийн үнэлгээний шкал) ашиглан хэмжсэн нийлмэл индекс юм. Энэ нь хүмүүсийг өөрсдийн амьдралыг байж болох хамгийн сайнаас (10 эсвэл 7) хамгийн муу (0) хооронд сайн сайхан байдлаа хэрхэн үнэлж байгааг асуудаг. Уг тайланд Кантрилын шкалын дундаж утгыг тооцоолдог аргачлалыг ашигласан. Субъектив сайн сайхан байдлыг хөтлөгч хүчин зүйлс юу болохыг нарийвчлан шинжлэхийн тулд оролцогчид болон тэдний өрхийн талаарх нийгэм хүн ам зүйн асуултууд гэх мэт мэдээллийг судалгааны явцад цуглуулсан.

Ашигласан материал

Aldar, Dolgion and Chultemsuren, Tamir (2015). *Defining social cohesion research design and indicators: in the case of Mongolia*. National University of Mongolia

Clifton, Jon (2017). *The Happiest and Unhappiest Countries in the World*. Gallup World Poll. <https://news.gallup.com/opinion/gallup/206468/happiest-unhappiest-countries-world.aspx>

Fukuyama, Francis (1995). *Trust: the social virtues and the creation of prosperity*. New York. Free Press.

Helliwell, J., Layard, R., & Sachs, J. (2017). *World Happiness Report 2017*. New York. Sustainable Development Solutions Network

Inglehart, R., C. Haerpfer, A. Moreno, C. Welzel, K. Kizilova, J. Diez-Medrano, M. Lagos, P. Norris, E. Ponarin & B. Puranen et al. (eds.). 2014. *World Values Survey: Round Six - Country-Pooled Datafile Version*: www.worldvaluessurvey.org/WVSDocumentationWV6.jsp. Madrid: JD Systems Institute.

Jenson, Jane (1998). *Mapping Social Cohesion: The State of Canadian Research*, Canadian Policy Research Networks

Larsen, Christian (2014). *Social cohesion: Definition, measurement and developments* <https://pdfs.semanticscholar.org/e2b4/6f29845743b214a522b3000eabca50052c0c.pdf>

OECD (2013). *OECD Guidelines on Measuring Subjective Well-being*. OECD Publishing

Stanley, Dick (2003). *What Do We Know about Social Cohesion: The Research Perspective of the Federal Government's Social Cohesion Research Network*. *The Canadian Journal of Sociology* Vol. 28, no. 1, 5-17

Uslaner, E.M. (2007). *The Generalized Trust Questions in the 2006 ANES Pilot Study*

Veenhoven, Ruut (2008). *Sociological theories of Subjective Well-Being In: Michael Eid & Randy Larsen (Eds), "The Science of Subjective Well-being: A tribute to Ed Diener"*. New York. Guilford Publications